

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЭЭХХЗГ-ААС ОРСОН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:					
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.					
3.3.1. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	АХ-2.2.24, МУХТЖҮЧ-2.2.7 ЗГҮАХ-2.1.8	3.3.1.1.Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах	Арга хэмжээний хэрэгжилт	100	Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд: 1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх 99 нэр төрлийн эм, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 225 нэрийн эм нийт 324 нэрийн эмийн үнийн санал авах захиалгыг НҮБ-ын Хүүхдийн санд 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн. Үнийн санал авах жагсаалтад багтсан 51 нэрийн эмийн тунг өөрчлөх, захиалгын тоо хэмжээг дахин баталгаажуулах саналыг НҮБ-ын Хүүхдийн сангаас 2024 оны 5 дугаар сарын 07-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн. Уг саналын дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 01/750, 01/751 дугаар албан бичгээр тус тус санал авч нэгтгэн 5 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар НҮБ-ын Хүүхдийн санд дахин хүргүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сангаас цахим каталогит үнэ байршсан 58 нэрийн эмийн үнийн саналыг 6 дугаар сарын нэгдүгээр 7 хоногт ирүүлэх ба бусад нэрийн эмийн тендерийн үйл ажиллагаа явагдаж байгаа тухай мэдээллийг 6 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн.

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
					2. “ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ЭМИЙН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМ” санаачлагыг хэрэгжүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй эм хүлээн авахтай холбоотойгоор эмийн хил дээрх зохицуулалтад оролцогч талуудын уулзалт, эм хүлээн авагч ЭХЭМҮТ, ЗӨСҮТ-ийн нийт 10 мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг Гаалийн ерөнхий газрын УБ хот дахь Гаалийн газартай хамтран 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор түүнийг дагалдан гарсан журам, жишиг баримт бичгүүд шинэчлэгдсэний дагуу эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нийт 87 мэргэжилтэнд хууль эрх зүйн мэдлэг, худалдан авах ажиллагааны цахим систем, цахим дэлгүүр системийн хэрэглээний мэдлэгийг нэмэгдүүлэх, олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг нэг эх үүсвэрээс худалдан авах журмыг танилцуулах зорилгоор Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран 3 өдрийн танхимын сургалт зохион байгуулах сургалтын удирдамж, төсвийн тооцооллыг Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн байна. Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, сайжруулах чиглэлээр ЭМЯ-ны СХГ-ын даргын баталсан 10-00/19, 10-00/11, 03-01/01 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд 378 байгууллагад хяналт шалгалт

Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин 2024	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
					хийж, 2020 заалттай 213 албан шаардлага, 3 иргэн, 27 ААН-д 17.8 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 2,2 сая төгрөгийн хууль бус орлого нөхөн төлүүлсэн байна. Мөн ЭМЯ-ны СХГ-ын даргын баталсан 10-00/23, ЭЭХХЗГ-ын ЧХГ-ын даргын баталсан 07/08, 07/09 дугаартай удирдамж, ЦЕГ-ын ХТТГ-тай хамтран баталсан хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд 371 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтад хамруулж, 31 заалттай 9 албан шаардлага, бүтээгдэхүүний дүгнэлт долоог үйлдэн 17 иргэн, 19 аж ахуйн нэгжид 27.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 36.9 сая төгрөгийн хууль бусаар олсон мөнгө орлогыг нөхөн төлүүлж, 21 нэрийн 2332 ширхэг зөрчилтэй бүтээгдэхүүнийг хураан орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн байна.

__oOo__